



СОЁЛЫН ӨВИЙН НЭГДСЭН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМД БАРИМТАТ ӨВИЙН БҮРТГЭЛ ХИЙХ ЗААВАР

Зорилго нь:

Монгол Улсын үндэсний баримтат өвийн жагсаалтад нэр дэвшүүлэх баримтат өвийн үнэнхүү хосгүй шинж байдал, гайхамшигт чанар болон ач холбогдлын талаар мэдээлэл цуглуулж дата бааз үүсгэх явдал болно.

Бүртгэл хийх баримтат өвийн бүртгэл хийх заавар:

Эхний шатанд

Танай аймаг, орон нутаг болон хувь хүн байгууллага баримтат өвийн жагсаалтад ямар өвийг оруулах нь зүйтэй вэ? гэдгийг шийднэ. Хэрэв танай аймаг орон нутаг, музей, номын сан, ОНСТ, сүм хийд, хувь хүний гар дээр хадгалагдаж буй баримтат өвийг нэгдсэн системд бүртгэхэд шаардлагатай нэмэлт мэдээллийг доорх хаягаар авч болно.

Хаяг: СӨҮТ -ийн Бүртгэл, судалгааны газар

Хан-Уул дүүрэг 21-р хороо

Буянт-Ухаа-2 хороолол

Соёлын Өвийн Үндэсний Төв

(Утас: 93123896)

Дараагийн шатанд

Нэгдсэн системд админы өгсөн нэвтрэх эрхийн дагуу орж баримтат өвийн бүртгэлийн мэдээллийг бэлтгэж боловсруулах ба системийн бүртгэлд оруулах заавар зөвлөмжийг доор өгөв. Шинээр бүртгэх баримтат өвийн мэдээллийг асуулга, шалгуурын дагуу бэлтгэж боловсруулахын өмнө энэхүү удирдамжийн **Алхам-3: Дэлгэрэнгүй мэдээлэл** хэсгийг сайтар уншиж судлаарай.

Шалгуур үзүүлэлтийг заавал яг тэр хэвээр нь бүгдийг тайлбарлах албагүй. Утгын дарааллыг алдагдуулахгүйгээр, шаардлагатай мэдээллийн хэмжээнд тохируулан 1-2 шалгуурыг илүү оновчтой гаргаж болно. Шинээр бүртгүүлэх өвийн талаар нэмэлт мэдээлэлд хэмжээ хязгаар тогтоохгүй.

Алхам 1

Баримтат өвийн бүртгэл → **Шинээр нэмэх** цэс рүү ороход

Өмчлөгч, эзэмшигчийн мэдээлэл гарч ирэх ба түүнийг асуултын дагуу үнэн зөв бөглөхөд болно . Доорх өгсөн зааврыг ашиглана уу.

- Нэгдсэн системд баримтат өвийн бүртгэл шинээр оруулах хувь хүн, байгууллагын бүтэн нэр бичнэ.
- Асуулт бүрт хариулт өгсөн байх ёстой. Жишээ нь хувийн эзэмшилд байна уу, олон нийтийн байгууллагын эзэмшилд байна уу, эсхүл худалдаа арилжааны байгууллагын эзэмшилд байна уу? гэдгийг тогтоосны дараа энэ хэсгийн мэдээллийг оруулна.
- Хэрвээ хувь бол Админы өгсөн эрхээр нэвтэрч системийн **Админ удирдлага** → **Өмчлөгч эзэмшигч** цэс рүү орж **+НЭМЭХ** товчийг дарж Хувь өмчлөгчийн мэдээлэл оруулж үндсэн хэрэглэгчид бүртгэл зөвшөөрөгдсөний дараа түүний баримтат өвийг бүртгэх боломжтой болно.
- Хувь хүний өмчлөлд буй баримтат өвийг сайн дурын үндсэн дээр бүртгэнэ.
- Хувь хүн хүсвэл СӨҮТ-д шууд өөрийн биеэр ирж бүртгүүлж болно.

Хувь хүн: Нэр, РД, оршин суугаа хаяг, утас майл хаяг Холбоо барьж ажиллах хүн (хүмүүс) Баримтат өвтэй ямар холбоотой болохыг үнэн зөв бүртгүүлнэ.

Төрийн өмчийн байгууллагууд өөрсдийн эрхийн дагуу шууд нэвтэрч дараах байдлаар бүртгэл хийнэ. (Хэрэглэгчийн эрхтэй хувь хүн мөн адил).

Системийн бүртгэлийн маягт дараах байдлаар өгөгдсөн болно. ҮҮНД:

- 1.1. Өмчийн хэлбэр: сонголт
- 1.2. Өмчлөгчийн нэр: гараас оруулна
- 1.3. Эзэмшигчийн нэр: сонголт
- 1.4. Музейн зэрэглэл : сонголт оруулаад Үргэлжлүүлэх товчийг дарна.

Алхам 2 Үндсэн мэдээлэл хэсгийг орхигдуулахгүй заавал бөглөх хэрэгтэй Хэрэв мэдээлэл орхисон тохиолдолд хадгалагдахгүй болохыг анхаар

2. Үндсэн мэдээлэл

- 2.1. Баримтат өвийн нэр: Гараас оруулна Нэр бүтэн байна хэрэв тэмдэгт хэтэрвэл хураангуй нэр байж болно.
- 2.2. Хувийн дугаар: Гараас оруулна
- 2.3. Баримтат өвийн жагсаалтын төрөл: сонгох
- 2.4. Үндэсний өвийн жагсаалтад бүртгэгдсэн эсэх: Сонгох (Шийдвэр нотолгоо гараас оруулна.
- 2.5. Төрөл зүйл сонгох 17 төрөл зүйл байна түүнээс сонгоно
- 2.6. Тоо ширхэг: гараас

- 2.6.1. Иж бүрдлийн бүрэлдэхүүн хэсгийн тоо ширхэг: Асуулт бүрд хариулт өгсөн байх ёстой
- 2.6.2. Эх бүтээл: Сонголт (Жинхэнэ эх мөн эсэх гарал үүсэл нь тогтоогдсон эсэхийг тогтоосон байна. Үүнийг тодорхойлолт хэсгээс харна.
- 2.6.3. Ховор, түгээмэл байдал: сонголт Энд энэхүү нэр дэвшүүлж буй өвийн нэн ховор байдал, бүрэн бүтэн байдлыг тогтоосон байх учиртай.
- 2.6.4. Ашиглалтын байдал: сонгох (Музей номын санд хамааралтай, хувь хүн тодорхойлолт хэсэгт оруулна).
3. Ерөнхий хэмжээ: Асуулт бүрд хариулт өгсөн байх ёстой
- 3.1. Материал: сонголт
- 3.2. Товч тодорхойлолт: Энэ бол шинээр бүртгэсэн өвийн мэдээллийг унших цонх тул анхаарлаа доорх агуулгад сайн хандуулаарай.

Шинээр бүртгүүлж буй баримтат өвийн ач холбогдолтой, эсэх, үнэнхүү хосгүй гайхамшигтай, юугаар ч орлуулшгүй бүтээл гэдгийг нотлон тогтоох ҮҮНД: Цаг хугацаа, газар нутаг, орон зай, ард түмэн, хүмүүс, агуулга болон сэдэв, ур хийц, төрөл хэлбэр болон хэв маяг, нийгмийн, оюун санааны ач холбогдлыг тодорхойлно.

4. Олон нийтэд зориулсан тайлбар: Баримтат өвийн мэдээллийг бүтэн оруулж дууссаны дараа бөглөх ёстой. Баримтат өвийн мэдээлэл аль болох сонирхолтой бөгөөд энгийн олон нийтэд ойлгомжтой байхаар бичээд үргэлжлүүлэх товчийг дарснаар 2-р алхам болно.

Алхам 3

Дэлгэрэнгүй мэдээлэл *Хэсэг бол бүртгүүлж буй баримтат өвийн шалгуур болно.*

Гол гол мэдээллийг хялбар ойлгогдохоор тоймлон дүгнэх нь чухал юм. Тухайн баримтат өв үндэсний хэмжээнд нөлөөтэй эсэхийн энэ цонхноос харах болно. Доорх шалгууруудыг бүгдийг ч бичиж болно. Бүртгүүлж буй өвд тохирсон нэг шалгуур ч бичиж болно. Харин хэрэглэгдэх шалгуур бүр дээр тайлбар өгсөн байх учиртай.

Шалгуур-1

Монголд болж байсан нийгмийн болон соёлын томоохон өөрчлөлтүүдийн ямар цаг үеийн ямар дурсамжийг илтгэн харуулсан бэ? Түүхэн онцгой үйл явдал, шинэ нээлт, хөгжил дэвшил, ухралт доройтлын талаар ямар мэдээ мэдээлэл агуулж байна вэ?

Шалгуур-2

Монголын төр, улс, нийгмийн харилцааны талаарх дүр төрхийг дүрслэн бичсэн үү? Мөн нөлөө бүхий түүхэн хувь хүн, хүмүүс, хотууд, үндэстэн угсаатан, нийгмийн бүлгүүдийн хэв маягийг тусгасан уу? Агуулга нь байгаль, нийгэм, хүмүүнлэгийн ухаан,

улс төр, үзэл суртал, спорт, урлаг дахь түүхэн болоод оюун санааны хөгжил дэвшлийг илтгэн харуулсан уу?

Шалгуур-3

Баримтат өв бий болж үүссэн нийгэм болоод соёлын орчин нөхцөл нь тэр үеийн газар нутаг, хүмүүсийн төрх байдал, амьдралын хэв маяг, соёл зан заншил, жендер, үйлдвэрлэл, урлаг болоод улс төр хөгжиж байсан чухал талуудыг тусгасан уу?

Шалгуур-4

Нэр дэвшүүлж буй өвийн түүх нь бичиг соёлын өвийн ердийн болон хамгийн сайн үлгэр загвар мөн үү? Устаж үгүй болсон юм уу, үгүй болж байгаа мэдээллийн тээгч болон хэв загварын ердийн болон хамгийн сайн жишээ байж чадах уу? бичээд үргэлжлүүлэх товчийг дарснаар 3-р алхам болно.

Алхам-4

Баримтат өв ба түүний хадгалагдаж байгаа газрын холбогдолтой гэрэл зураг, дүрс бичлгийн хэсэг юм

4.1. Бүртгэн баримтжуулалтын гэрэл зураг

4.2 Уран сайхны зураг

4.3 Дүрс бичлэг оруулаад Баримтжуулалтын хэсгийг сонгоод Хадгалах товчийг дарснаар 4-р алхам дуусна.

Ингэснээр таны бүртгэсэн баримтат өв системд Шинээр бүртгэсэн төлөвт хадгалагдах болно. **Үйлдэл хэсэгт: Харах, Засах, Хэвлэх үйлдэл** хийж болно. Харин

Төлөв өөрчлөх хэсэгт хандахгүй.